

Жижиг улсын гадаад бодлогын “hedging” стратеги: Олон улсын аюулгүй байдлын хуваагдмал орчинд хэрэгжүүлэх боломж, сорилт

Бадарчийн Алтанхүү

Ахлах шинжээч, хурандаа, altankhuu@iss.gov.mn
Монгол Улс, Улаанбаатар, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн
Стратеги судалгааны хүрээлэн

Хураангуй

Улам бүр хуваагдаж буй олон улсын аюулгүй байдлын өнөөгийн орчинд “hedging” стратеги нь жижиг улсуудын хувьд хязгаарлагдмал болж буй хэдий ч үндэсний аюулгүй байдлаа хамгаалах, маневр хийх орон зайгаа хадгалах чухал стратеги байсаар байна. Монгол Улсын хувьд “hedging” стратегийн хоёр талт байдлын бодит жишээ юм. Энэ стратегийг ашиглан хүч тэнцвэргүй харилцааны хамаарлыг даван туулах зайлиггүй шаардлага байдаг бол геополитикийн туйлшрал гүнзгийрэхийн хэрээр энэ стратегийн эмзэг байдал нэмэгддэг. “Hedging” стратегийн орон зай хумигдаж байгаа нь жижиг улсуудын бие даасан байдлаа тодорхой хэмжээнд хадгалах, стратегийн тодорхойгүй байдлыг удирдах болон эрсдэлийг тэнцвэржүүлэх прагматик боломжийг бүрмөсөн хааж буй хэрэг биш юм. Энэхүү өгүүлээр геополитикийн хуваагдмал нөхцөлд жижиг улсуудын дасан зохицох стратегийн талаарх өргөн хүрээний хэлэлцүүлэгт хувь нэмэр оруулахыг зорьсон болно.

Түлхүүр үг: “Hedging” стратеги; Жижиг улс; Хуваагдмал олон улсын аюулгүй байдлын орчин; Стратегийн бие даасан байдал

Оршил

Энэхүү өгүүлэлд “hedging” хэмээх ойлголтыг жижиг болон дунд хэмжээний улс орнууд хоёр буюу түүнээс дээш том гүрэнтэй харилцахдаа өөр хоорондоо ялгаатай бодлогыг зэрэгцүүлэн хэрэгжүүлэх замаар эрсдэлийг бууруулах, боломжоо нэмэгдүүлэх зорилготой стратеги гэж авч үзэв. Жижиг улсууд олон улсын тогтолцоонд том гүрнүүдийн дунд оршин тогтнох, бие даасан байдлаа хадгалах гэсэн хоёрдмол сорилттой үргэлж тулгардаг. Их гүрнүүдийн өрсөлдөөн хурцдаж, тэдгээрийн хүчний харьцаа өөрчлөгдөж, олон улсын тогтолцоо тодорхойгүй, олон талт, харилцан хамаарал бүхий нөхцөл байдалд байгаа үед тэнцвэржүүлэх, аялдан дагалдах, төвийг сахих зэрэг уламжлалт гадаад бодлогын стратегийг дангаар нь хэрэгжүүлэх улам бүр амаргүй болж байна. Ийм нөхцөлд эрсдэлээс сэргийлэх, ашиг сонирхлоо хамгаалах зорилготой уян хатан “hedging” стратеги баримтлах нь жижиг улсуудын хувьд прагматик арга болжээ.

Гэвч олон улсын өнөөгийн харилцаанд “hedging” стратегийг ашиглах орон зай хязгаарлагдмал болж байна. Тухайлбал: Украины дайн эхэлснээс хойш олон улсын аюулгүй байдлын орчин улам бүр хуваагдал давамгайлсан шинжтэй болж байгаагаас үүдэн жижиг улсуудын оршин тогтнох, стратегийн маневр хийх боломж хумигдаж байна. Жижиг улсын зүгээс аль нэг их гүрнийг хэт дагалдахгүй байх стратегийн тодорхойгүй байдал урьд өмнө аюулгүй байдлаа хамгаалах нэг чухал арга болж байсан бол өдгөө их гүрнүүдийн өрсөлдөөнөөс үүдэлтэй “хардалт сэрдэлт” үүсгэх, үл итгэлцэл төрүүлэх, дарамт, шахалтад өртөх нэг шалтгаан болох болжээ. Мөн эдийн засгийн хувьд хамааралтай байдлыг “зэвсэг болгон ашиглах”, хориг арга хэмжээ авах, технологийн хувьд хянах зэрэг шинэ хэлбэрийн шахалт жижиг улсуудыг аль нэг талд илүү хамааралтай мэт харагдуулах, хүчээр хамааралтай байдалд орох эрсдэлийг бий болгож байна.

Монгол Улс хоёр том гүрний дунд байрлаж байгаа хэдий ч “гуравдагч хөрш”-ийн бодлогоор дамжуулан стратегийн тэнцвэр барьж, олон талт хамтын ажиллагааг эрэлхийлж байгаа нь “hedging” стратегийн боломж, сорилтыг дагуулж байна.

Энэхүү өгүүлэлд “Hedging” стратеги нь хуваагдмал дэлхийд ч прагматик, ач холбогдол бүхий стратеги хэвээр байгааг цөөн тооны улсын жишээн дээр авч үзэхийн зэрэгцээ жижиг улсуудад үндэсний аюулгүй байдлаа хангах, стратегийн уян хатан байдлаа хадгалахад нь зайлшгүй чухал стратеги гэдгийг нотлохыг зорив. Үүний тулд эхлээд “hedging” стратегийн онолын үндэс, судлагдсан байдал, жижиг улсын аюулгүй байдлаа хангах стратегийн талаар тоймлон авч үзээд олон улсын аюулгүй байдлын өнөөгийн хуваагдмал орчны онцлог, системийн түвшний зарим өөрчлөлтийг товч тайлбарлав. Эцэст нь жижиг улс хэрхэн хариу стратегиа төлөвлөж, “hedging” стратегийг хэрэгжүүлэх боломж, хязгаар, дасан зохицох чадвараа тодорхойлж байгааг харьцуулан шинжилнэ.

Нэг. “Hedging” стратегийн онолын үндэс ба судлагдсан байдал

“Hedging” стратегийн тухай ойлголт 2000-аад оны эхэн үеэс олон улсын харилцааны судлалд түрэн орж ирэх болжээ. Ялангуяа Зүүн Өмнөд Азийн улс орнуудын АНУ болон БНХАУ-ын дунд баримталж буй гадаад бодлогын зан үйлийг тайлбарлахад өргөн хэрэглэгдэх болсон. Энэхүү ойлголтыг Эвелин Го¹ “хатуу сонголт хийхээс зайлсхийх стратеги” гэж тодорхойлсон байдаг. Түүний тайлбарласнаар их гүрнүүдийн өрсөлдөөн, системийн тодорхой бус байдлын үед жижиг болон дунд хэмжээний улсууд аль нэг талыг хэт аялдан дагалдахын оронд тэдэнтэй хамтран ажиллахын зэрэгцээ эрсдэлээс сэргийлэх арга хэмжээ авах замаар өөрийн ашиг сонирхлыг хамгаалдаг байна.

Нөгөөтгээгүүр, Чэнг-Чүи Күик² “hedging” стратегийн логикийг нарийвчлан

¹ Evelyn Goh, *Meeting the China Challenge: The U.S. in Southeast Asian Regional Security Strategies*, Policy Studies 16 (Washington, DC: East-West Center, 2005).

² Cheng-Chwee Kuik, “The Essence of Hedging: Malaysia and Singapore’s Response to a Rising China,” *Contemporary Southeast Asia* 30, no. 2 (2008): 159–185.

тайлбарлаж, хоёр чиглэлтэй стратеги гэж тодорхойлжээ. Тэрээр “hedging” стратегийн мөн чанарыг (1) их гүрнүүдтэй эдийн засаг, аюулгүй байдал, технологийн салбарт хамтран ажиллаж боломжоо нэмэгдүүлэх арга хэмжээ; (2) аль нэг талаас хэт хамааралт байдлыг бууруулах, болзошгүй эрсдэлийг хязгаарлах хариу арга хэмжээ хоёрын нэгдэл юм гэж тайлбарласан. Ийм хоёр чиг хандлага зэрэгцэн орших нь “hedging” стратегийг тэнцвэржүүлэх болон аялдан дагалдах стратегиас ялгагдах шинж болдог. Тэнцвэржүүлэх стратеги нь сөргөлдөх, өрсөлдөх зорилготой бол аялдан дагалдах стратеги нь бүрэн хамаарал үүсгэх хандлагатай. Харин “hedging” нь энэ хоёрын дунд орших уян хатан, эрсдэлээс сэргийлэх стратеги юм.

“Hedging” стратеги нь тодорхойгүй орчинд эрсдэлийн эсрэг даатгалын механизмын адил үүрэг гүйцэтгэдэг.³ Ийм учраас аливаа улсад нэг талаас хамтын ажиллагаагаар боломжоо хадгалах, нэмэгдүүлэх, нөгөө талаас хамгаалалтын арга хэмжээ авч эрсдэлээ хязгаарлах боломж олгодог.


Олон улсын харилцаанд жижиг улсуудын гадаад бодлого нь ихэнхдээ асимметрик буюу хүч тэнцвэргүй харьцаанд тулгуурлана. Тэдний зүгээс хүчний тэнцвэрийг өөрчлөх чадвар хязгаартай тул стратегийн сонголтоо нарийн тооцоолж хийх шаардлагатай болдог. Жижиг улсын аюулгүй байдлаа хангах гурван стратеги байх бөгөөд үүнд: (1) аюулын эсрэг холбоотонтой болох, эсхүл зэвсэгт хүчнээ хүчирхэгжүүлэх-тэнцвэржүүлэх стратеги; (2) нэг улстай ойртон түншлэх замаар хамгаалалт, өөрт ашигтай нөхцөл бүрдүүлэх-аялдан дагах стратеги; (3) аль нэг талд нэгдэхгүй төвийг сахих стратеги зэрэг болно. Иймд жижиг улс аль нэг талыг илт дагахгүйгээр хамтран ажиллахын зэрэгцээ эрсдэлээс сэргийлэх арга хэмжээг зэрэг авч хэрэгжүүлдэг стратеги нь “hedging” юм. Энд стратегийн гол санаа нь тодорхой бус байдлыг зориуд хадгалж, маневрлах боломжоо хамгаалахад оршино.

Чэнг-Чүи Күик үүнийг “хүчний хариу үйлдлийн хамрах хүрээ”(power-response spectrum) гэх загвараар дүрсэлж, улсуудын хариу үйлдлийг итгэлцэл-болгоомжлолын тэнцвэр дээр тодорхойлсон. Түүний 2008 онд боловсруулсан онолын энэ загвар улс орнуудын гадаад орчны хүчний нөлөөнд үзүүлэх хариу үйлдлийг “хүчийг хүлээн зөвшөөрөх” (power acceptance) болон “үл зөвшөөрөх” (power rejection) гэсэн хоёр туйлын хооронд үргэлжилсэн спектр хэлбэрээр тайлбарладаг. Энэхүү спектр нь “hedging” стратегийн гол агуулгыг хамтын ажиллагаа ба болгоомжлолыг зэрэгцүүлэн хэрэгжүүлэх зан үйлээр тодорхойлдог (Зураг 1).

³ Goh, Meeting the China Challenge, 45

Зураг 1. Хоёр туйлын хооронд үргэлжлэх спектр

Power-Response Spectrum



Тэрээр энэ загварыг ашиглан гадны хүчийг хүлээн зөвшөөрөх болон үл зөвшөөрөх гэсэн хоёр туйлын хооронд “hedging” стратегийг байрлуулж, хосолмол стратеги гэж тодорхойлсон. Улс орнууд өөрсдөө гадаад орчныхоо итгэлцэл болон эрсдэлийн түвшин, ашиг сонирхлын зөрүүнд үндэслэн “hedging” стратегийнхаа түвшнийг тодорхойлдог. Эндээс жижиг улсын хувьд “hedging” нь үндсэн дөрвөн зорилготой нь харагдаж байна. Үүнд: (1) стратегийн уян хатан байдлыг хадгалах; (2) их гүрнүүдийн шахалтад өртөхөөс сэргийлэх; (3) эдийн засгийн болон технологийн хамаарлын эрсдэлийг тэнцвэржүүлэх; (4) гадаад бодлогын хувьд ирээдүйд маневр хийх боломжоо нээлттэй үлдээх явдал юм.

Хэдийгээр “hedging” стратегийн анхны ойлголт Зүүн Өмнөд Азийн орнуудын зөвшилцөх зарчмыг баримталсан туршлагад тулгуурласан хэдий ч сүүлийн жилүүдэд энэ ойлголт олон улсын анхаарлыг илүүтэй татах болжээ. Лим⁴, Ачария⁵, Катценстайн⁶ нарын үзэж байгаагаар “hedging” стратегийн ач холбогдол нь зөвхөн хоёр гүрний хоорондох тэнцвэрийн асуудал төдий биш олон төвтэй, сүлжээжиж холбогдсон, хуваагдмал олон улсын орчинд жижиг улс орнууд хэрхэн дасан зохицох вэ гэдгийг тайлбарлахад оршдог. Лим “hedging” стратегийг “үргэлжилсэн, тухайн нөхцөлд уялдсан процесс” гэж тодорхойлсон. Өөрөөр хэлбэл: “hedging” бол нэг удаагийн шийдвэр бус харин тодорхой нөхцөл бүрдэхэд хэлбэрээ өөрчилдөг улс орны зан үйлийн загвар юм. Улс орон аюулгүй байдлын нөхцөл байдлын өөрчлөлттэй уялдуулан “hedging” стратегийн эрчим, хэлбэрээ байнга өөрчилдөг.

Ачария, Катценстайн нарын хувьд хуваагдмал дэлхий гэх ойлголт нь өнөөгийн олон улсын дэг журмыг тайлбарлах гол түлхүүр ойлголт гэж үздэг. Тэдний үзэж байгаагаар хууль, дүрэмд тулгуурласан дэг журам суларч, олон төвтэй, сүлжээ бүхий, бүс нутаг, тодорхой салбарын хувьд хуваагдмал олон улсын орчин бий болсон. Ийм орчин жижиг улсуудыг улам нарийн төвөгтэй “hedging” стратеги хэрэгжүүлэхэд хүргэж байгаа юм. Тэдний судалгаанаас (1) “hedging” стратеги бол нөхцөл байдлын өөрчлөлтөд дагаж хэлбэрээ өөрчилж байдаг динамик процесс; (2)

⁴ Da-Hoon Lim, “Hedging in the Contemporary Security Environment,” *Asian Perspective* 41, no. 3 (2017): 387–406.

⁵ Amitav Acharya and Peter J. Katzenstein, *The Making of Global International Relations: Origins and Evolution of IR at Its Centenary* (Cambridge: Cambridge University Press, 2023).

⁶ Acharya and Katzenstein, *The Making of Global International Relations*, 88

“hedging” стратегийн хэрэгцээ маш чухал болж байгаа ч хэрэгжүүлэх орон зай нь хумигдаж байна; (3) “hedging” стратеги нь жижиг улсын сөрөн тэсвэрлэх чадавх буюу тогтвортой байдалтай шууд холбоотой стратеги юм гэсэн байна.

Хоёр. Олон улсын аюулгүй байдлын хуваагдмал орчин, сорилт

XXI зууны гуравдагч арванд дэлхийн аюулгүй байдлын орчин хуваагдал, өрсөлдөөн, тодорхойгүй байдал давамгайлсан шинжтэй болж, даяарчлалын тогтолцоонд өөрчлөлт оруулах хандлагыг бий болгож байна. АНУ-БНХАУ-ын стратегийн өрсөлдөөн зөвхөн цэрэг-стратегийн төдийгүй эдийн засаг-технологийн хүрээнд дүрэм, стандарт, нийлүүлэлтийн сүлжээг хамрах болов.⁷ Олон улсын аюулгүй байдлын хуваагдмал орчныг (1) системийн хуваагдал; (2) эдийн засгийн хамаарал ба хуваагдал; (3) олон улсын институтийн сулралын хүрээнд товч авч үзэж болно.

1. Хүйтэн дайны дараах нэг туйлт үе үндсэндээ дуусаж, АНУ, БНХАУ, ОХУ-ын хооронд хүчний харьцангуй шилжилт явагдаж, бүс нутгийн хэмжээний бусад төвүүд зэрэгцэн орших боллоо. Үүний дүнд олон төвт-төвлөрсөн бус дэг журам бүрэлдэж, улс орнууд дэлхийн, бүс нутгийн, салбар бүс нутгийн зэрэг дэг журмын олон давхаргад сонгон оролцдог болж байна. Дээрх гурван улсыг гол гурван төв болгон харвал дэлхийн эдийн засаг, технологи, аюулгүй байдлын бүтэц гурван өөр экосистемд хуваагдсан харагдана. Тухайлбал: АНУ-ын өнөөгийн Ерөнхийлөгчийн зүгээс урьдчилан таамаглах боломжгүй бодлого, шийдвэрүүд сүүлийн жил орчмын хугацаанд хэрэгжиж байгаа хэдий ч тус улс нь ардчилал, либерал үнэт зүйлс, чөлөөт зах зээлийг голлох тулгуур болгон НАТО болон Энэтхэг-Номхон далайн бүс нутгийн эвсэл, түншүүдээр дамжуулан дүрэм, журамд тулгуурласан дэлхийн дэг журмыг хамгаалахыг хичээж ирсэн. БНХАУ-ын хувьд дэлхийн эдийн засгийн нэг гол тулгуур болж, “Бүс ба Зам” санаачилга болон ШХАБ, БРИКС зэрэг олон улсын платформуор дамжуулан өөрийн нөлөөг өргөжүүлж байна. Харин ОХУ нь ЗХУ-ын үеэс улбаатай уламжлалт геополитикийн нөлөөгөө сэргээхийг зорьж, Украины дайнаар дамжуулан Өрнөдийн эсрэг стратеги хэрэгжүүлэх замаар өөрийн аюулгүй байдлын орон зайг хамгаалахыг оролдож байгаа юм.

Энэ гурван гүрэн хоорондын хүчний харьцангуй шилжилт, бүс нутгийн хязгаарыг үл харгалзан хийж буй өрсөлдөөн, түүнчлэн технологийг шахалт үзүүлэх хэрэгсэл болгон ашиглаж байгаа нь өнөөгийн олон улсын дэг журмыг дахин хоёр туйлд ойртуулж болзошгүй байна. Түүнчлэн Европын Холбоо болон Энэтхэг, Япон зэрэг бүс нутгийн төв болсон улс ч бие даасан стратеги боловсруулан хэрэгжүүлж олон төвтэй, төвлөрсөн бус тогтолцоог бий болгоход ихээхэн нөлөө үзүүлж байна.

2. Олон улсын эдийн засгийн харилцаанд улс орнууд харилцан хамаарлаа бие биеийн эсрэг “зэвсэг” болгон ашиглах хандлага нэмэгдэж байна. Тухайлбал: АНУ, БНХАУ-ын технологийн өрсөлдөөн, хагас дамжуулагчийн хориг, нийлүүлэлтийн сүлжээний хуваагдал, тарифын асуудал нь дэлхийн худалдааны дэг журамд сөргөөр

⁷ Chatham House, “Trump’s Economic Rivalry with China Is Forcing Countries to Pick a Side,” *The World Today*, September 15–17, 2025.

нөлөөлж байгаа. Сүүлийн үед хурцаар яригдаж буй АНУ-ын тариф, БНХАУ-ын газрын ховор элементийн хязгаарлалт нь үүний тод жишээ юм.⁸ Эдийн засгийн хориг арга хэмжээ, санхүүгийн зах зээлийн хязгаарлалт, экспортын хяналт зэрэг нь жижиг улсуудын стратегийн уян хатан байдлыг эрс хязгаарлаж технологи, санхүүгийн асуудлаар аль нэг талыг барихад хүргэж байна. Түүнчлэн худалдааны бодлогыг дан эдийн засгийн бус дипломат хэрэгсэл болон хувиргаж байгаа нь энэ шилжилтийг илэрхийлж байгаа нэг шинж юм.

Энэ нөхцөлд аюулгүй байдлын орчны стратегийн тодорхой бус байдал улам нэмэгдэх бөгөөд улс орнууд эдийн засаг, эрчим хүч, технологийн аюулгүй байдлын сүлжээгээ шинэчлэн зохион байгуулахад хүрч байна. Мөн улс орнууд аль нэг талаас гүнзгий хамааралтай болохоос зайлсхийж, олон чиглэлд эрсдэлээс сэргийлэх шаардлагатай болно.

3. Олон улсын аюулгүй байдлын орчны хуваагдлын нэг гол илрэл бол олон улсын байгууллагуудын нөлөө буурч буй явдал. НҮБ, Дэлхийн худалдааны байгууллага, Олон улсын валютын сан зэрэг байгууллага том гүрнүүдийн ашиг сонирхлын сөргөлдөөнд үйл ажиллагаа явуулах боломж нь хязгаарлагдаж, шийдвэр гаргах чадвар нь сулрах хандлагатай болсон. Харин шинэ бүлэглэлүүд, тухайлбал: Их 7 ба БРИКС, НАТО ба ШХАБ зэрэг платформ өөр хоорондоо өрсөлдөх шинжтэй бүтэц болон хувирч байна. Энэ нөхцөл байдлыг Ачария “либерализмын дараагийн бужигнаан” гэж нэрлэсэн байдаг. Түүний үзэж байгаагаар дэлхийн дэг журам одоо төвгүй, дүрэм журам султай, итгэлцэл багатай болсон. Ийм нөхцөлд улс бүр өөрийн ашиг сонирхолдоо нийцсэн хэлбэрээр олон улсын харилцаанд хэсэгчлэн оролцох болжээ.

Энэхүү хуваагдал, тодорхойгүй байдал нь жижиг улсуудад хоёрдмол үр дагавар авчирч байна. Тухайлбал: олон төвт орчин нь жижиг улсуудад илүү олон түнштэй харилцаж, олон талт бодлого хэрэгжүүлэх боломжийг хадгалж, стратегийн хувьд хэн нэгнээс хэт хараат бус байх зарчмын чухлыг харуулж байна. НҮБ-ын үйл ажиллагааны эерэг дүн хязгаарлагдмал, том гүрнүүд олон улсын эрх зүйг зөрчсөнөөр түүний үр нөлөөг сулруулж буйгаас жижиг улсуудын олон талт хамтын ажиллагаагаар аюулгүй байдлаа баталгаажуулах боломж нь хомсдож, стратегийн уян хатан байдал нь хумигдахад хүрч байгаа юм. Ингэснээр бүс нутгийн болон хоёр талын түвшинд хязгаарлагдмал түншлэлд түшиглэхээс аргагүй байдалд хүргэх нөлөөтэй байгаа юм. Энэ нь “hedging” стратегийн хэрэгцээг улам нэмэгдүүлж, хэрэгжүүлэх суурь нөхцөл болж байна. Мөн энэ стратегийг амжилттай хэрэгжүүлэхэд улам илүү нарийн тооцоолол, мэдрэмж шаардах болов.

Гурав. “Hedging” жижиг улсын хариу стратеги болох нь

Жижиг улсуудын хувьд “hedging” стратегийн гол агуулга нь олон улсын аюулгүй

⁸ Al Jazeera, “China Tightens Export Controls on Rare-Earth Metals: Why This Matters.” October 10, 2025, <https://www.aljazeera.com/news/2025/10/10/china-tightens-export-controls-on-rare-earth-metals-why-this-matters>

байдлын тодорхой бус орчинд боломжоо нэмэгдүүлэх ба эрсдэлийг хязгаарлах хоёр чиглэлийг зэрэг авч явахыг хэлнэ. Нэг талд бусад улстай хамтын ажиллагааг гүнзгийрүүлэхийн зэрэгцээ нөгөө талд аль нэг улсаас бүрэн хамаарал үүсэхээс сэргийлсэн бодлого, үйл ажиллагаа хэрэгжүүлэх юм. Энэхүү хоёр талт логик нь жижиг улсуудад аль нэг талыг хэт аялдан дагалдахгүй байх боломжийг олгохын зэрэгцээ бодит нөхцөлд нарийн тооцоотой байр суурь баримтлах нөхцөл бүрдүүлдэг.

Энэхүү уян хатан байдлыг хэрэгжүүлэх үндсэн гурван чиглэл бий. Нэгд, гадаад харилцааны хэмнэл, хуваарийг нарийн төлөвлөж, түншүүдтэйгээ харилцаа, яриа хэлэлцээний давтамжийг тэнцвэртэй барина. Ингэснээр аль нэг талд орсон мэт харагдах эрсдэлийг эдгээр уулзалтын давтамжаар тэнцвэржүүлж чадна. Хоёрт, эдийн засаг, санхүү, нийлүүлэлтийн хамгаалалтын бүтэц бий болгоно. Ганц зах зээл, худалдааны коридор, стандартад хэт түшиглэхгүй, боломжтой бол хоёр болон түүнээс дээш эх үүсвэрийн нөөцөө бүрдүүлнэ. Гуравт, түншүүд болон олон нийтэд чиглэсэн стратегийн мэдэгдлийг тогтмол, тэнцвэртэй хүргэнэ. Ингэснээр бүгдтэй нээлттэй, хэнд ч дайсагнаагүй, дүрэмд суурилсан бодлого баримталж буйгаа тууштай харуулах юм.

Хуваагдмал олон улсын орчинд бүх салбарыг ижил түвшинд тэнцвэржүүлэх боломж хомс байдаг учир жижиг улсууд ихэвчлэн салбар тус бүрийн мэдрэмтгий байдлыг харгалзсан стратеги баримтлах шаардлагатай болно (Хүснэгт 1). Тухайлбал: өндөр мэдрэмтгий салбарууд болох цахим дэд бүтэц, чип, батлан хамгаалах, төлбөр тооцооны асуудал дээр илүү сэрэмжтэй ажиллана. Эдгээр салбарт хууль, стандартын нийцтэй байдал, нөөц, давхар нийлүүлэлтийн боломжийг бэхжүүлэх нь стратегийн эхний ээлжийн гол алхам болно. Харин дунд зэргийн мэдрэмтгий салбарууд болох эрчим хүч, логистик, уул уурхайн хувьд эх үүсвэрээ төрөлжүүлэх, дунд хугацааны тогтвортой гэрээ байгуулах, эрсдэлээс хамгаалах зохицуулалт хийх нь чухал. Харьцангуй бага мэдрэмтгий салбарууд болох соёл, боловсрол, аялал жуулчлал зэрэгт илүү өгөөж, боломж бий болгох чиглэлд анхаарч, зөөлөн хүчний хүрээнд хамтын ажиллагааг идэвхжүүлэх боломжтой.

Хүснэгт 1. Салбаруудын мэдрэмтгийн байдлын ангилал, зорилтот стратеги

Мэдрэмтгий байдал	Салбарууд	Зорилтот стратеги
Өндөр	Батлан хамгаалах, цахим дэд бүтэц, чип, төлбөр тооцоо	Хамгаалалт, эрсдэлийн хязгаарлалт
Дунд	Эрчим хүч, уул уурхай, логистик	Төрөлжүүлэлт, дунд хугацааны тогтвортой гэрээ
Бага	Соёл, боловсрол, аялал жуулчлал	Боломж нэмэгдүүлэх хамтын ажиллагаа, зөөлөн хүч

Дээрх байдлаар салбар тус бүрд өөр стратеги хэрэглэх нь нийт дүнгээрээ төвийг сахисан мэт байр суурийг илэрхийлэхэд хүрдэг талтай. Тухайлбал: Вьетнам боломж–эрсдэлийн тэнцвэрийг үйлдвэрлэлийн сүлжээний бодлоготой уялдуулан “hedging”

стратегийг хэрэгжүүлэх сайн жишээ болдог. АНУ–БНХАУ-ын өрсөлдөөн гүнзгийрч буй нөхцөлд Вьетнам өндөр технологийн үйлдвэрлэл, экспортын сүлжээг татах замаар эдийн засгийн ашиг хүртэхийн зэрэгцээ аюулгүй байдлын хамтын ажиллагааг аль ч талд хэт хэлбийхгүйгээр, уян хатан хэлбэрээр авч явж ирсэн. Энэ нь үйлдвэрлэлийн сүлжээний өгөөжөөр баталгаажсан маневр хийх боломжийг бий болгосон бөгөөд гадаад орчны гэнэтийн савлагаанд эмзэг бус байх нөхцөлийг бүрдүүлж байна.

Финландын жишээ жижиг улс институтын сөрөн тэсвэрлэх чадавхаа бэхжүүлэх замаар стратегийн сонголтын орон зайг хэрхэн бүрдүүлдгийг харуулдаг. Энэ улс эрсдэлийн үнэлгээ хийх, хууль эрх зүйгээ шинэчлэх, стратегийн нөөцөө бий болгох, олон талт хамтын ажиллагаагаа үе шаттай өргөжүүлэх замаар шаардлагатай цаг үед стратегийн зоримог шилжилт хийх (Европын Холбоонд элсэх, улмаар НАТО-д нэгдэх) урт хугацааны бэлтгэлээ бүрдүүлсэн. Ингэснээр Финландын “hedging” стратеги нь богино хугацааны маневр биш харин дотоод тогтолцоонд суурилсан урт хугацааны стратегийн уян хатан тогтолцоо болон төлөвшсөн.

Сингапурын хувьд жижиг улс өрсөлдөх давуу талаа стратегийн хэрэгсэл болгон ашиглаж чаддагийн тод жишээ юм. Санхүү, логистик, эрх зүйн өндөр стандарт бүхий үйлчилгээний дэд бүтэц нь тус улсад геополитикийн туйлшралын үед ч төвийг сахисан байр сууриа эдийн засгийн бодит өгөөжөөр хамгаалах боломжийг бүрдүүлдэг. Өөрөөр хэлбэл: Сингапурын чанартай хууль эрх зүй, сайн засаглал, дэлхийн жишигт нийцсэн стандарт нь “hedging” стратегийг системийн түвшний баталгаатай механизм болгон ашиглах боломжийг олгожээ. Эдгээр жишээ нь “hedging” стратеги үйлдвэрлэлд суурилсан, институтд суурилсан, стандарт-давуу талд суурилсан хэлбэрээр ялгаран хэрэгжиж болохыг харуулж байна.

Монголын “hedging” стратегийг богино хугацааны хамгаалалтын болон дунд хугацааны чадавх бэхжүүлэх хоёр үе шаттайгаар ойлгож болно. Хоёр их гүрний дунд орших геостратегийн орчин, эрчим хүч, тээвэр-логистикийн хамаарал зэрэг суурь хязгаарлалт “hedging” стратегийг хэрэгжүүлэх боломжийг тодорхой хэмжээнд хязгаарладаг. Гэсэн хэдий ч Монгол Улс хоёр хөрштэйгөө бүхэлдээ тэнцвэртэй харилцах,⁹ “гуравдагч хөрш”-ийн бодлого хэрэгжүүлэх,¹⁰ олон талт хамтын ажиллагаа явуулах, энхийг сахиулах ажиллагаанд тогтмол оролцох замаар тодорхой түвшний стратегийн уян хатан байдлаа хадгалсаар ирсэн. Харин богино хугацаанд олон салбарт нөөц бүрдүүлэх, давхар эх үүсвэр бий болгох, тээврийн боломжийг нэмэгдүүлэх зэрэг хамгаалалтын алхам шаардлагатай. Харин дунд хугацаанд дотоод чадавхыг дээшлүүлэх, эрх зүйн орчныг сайжруулах, нийлүүлэлтийн сүлжээг төрөлжүүлэх зэргээр “hedging” стратегийг хэрэгжүүлэх орон зайг бодитой тэлэх боломжтой юм.

Эдгээр туршлагаас харахад “hedging” стратеги нь улс орнуудын хувьд нэг ижил

⁹ Монгол Улсын Үндэсний Аюулгүй байдлын үзэл баримтлал (Улаанбаатар: Монгол Улсын Их Хурал, 2010) 3.1.1.4.

¹⁰ Монгол Улсын Гадаад бодлогын үзэл баримтлал (Улаанбаатар: Монгол Улсын Их Хурал, 2011) 14.2.

хэлбэрээр хэрэгждэг жор биш харин тухайн улсын институтийн чадавх, эдийн засгийн бүтэц, геостратегийн байрлалаас хамааран тасралтгүй өөрчлөгдөж байдаг динамик стратеги гэж ойлгож болно. Жижиг улсуудад гол сорилт нь олон салбарт нэгэн зэрэг тэнцвэржүүлэх бус, харин салбар тус бүрийн мэдрэмтгий байдалд суурилсан нарийн түвшний сонголт хийх явдал билээ.

Дүгнэж үзэхэд “hedging” стратегийг амжилттай хэрэгжүүлэхэд таван гол зарчмыг анхаарах шаардлага бий. *Нэгдүгээрт*, салбар тус бүрийн мэдрэмтгий байдлыг харгалзан “өндөр” дээр хамгаалалт хийх, эрсдэлээс сэргийлэх, “бага” дээр боломжийг хадгалах, шинээр бий болгох чиглэл баримтлах; *Хоёрдугаарт*, боломжтой бүхий л тохиолдолд, гаднаас хамааралтай салбарт эх үүсвэрийн нөөцтэй байх шаардлагатай бөгөөд нэг систем доголдоход нөгөөд шуурхай шилжих боломж бүрдүүлэх; *Гуравдугаарт*, хууль эрх зүй, санхүү, хүний нөөц, мэдээллийн дэд бүтэц зэрэг суурь бүтэц бэхжүүлэх замаар үндэсний сөрөн тэсвэрлэх чадавхаа бэхжүүлсэн байх; *Дөрөвдүгээрт*, гадагшаа нээлттэй, найрсаг, дүрэмд суурилсан байдлаар хандах зарчмыг тууштай баримталж, стратегийн мэдэгдлийг тогтвортой цацах; *Тавдугаарт*, гадаад түншүүдтэй харилцах харилцааны хэмнэл, давтамжийг тэнцвэртэй байлгах, аливаа шахалт орж ирэх тохиолдолд цаг хугацааны тогтсон зохион байгуулалтаар түүний нөлөөг саармагжуулах, зөөлрүүлэх боломжтой байх зэрэг зарчим болно.

Дүгнэлт

Геополитикийн өрсөлдөөн гүнзгийрч, нийлүүлэлтийн сүлжээ болон технологийн орчинд хуваагдал гүнзгийрэхийн хэрээр “hedging” стратегийг хэрэгжүүлэх боломж улам багасах нийтлэг дүр зураг ажиглагдаж байна. Энэ нөхцөлд системийн түвшний өөрчлөлтөөс илүү тухайн улсын сөрөн тэсвэрлэх чадавх, институтийн чадвар, салбар тус бүрийн мэдрэмтгий байдал, стратегийн уян хатан байдлыг хадгалах боломж нь жижиг улс орны бодлогын орон зайг тодорхойлох гол хүчин зүйл болно.

Үйлдвэрлэлийн сүлжээнд тулгуурласан Вьетнамын олон талт бодлого, дотоод сөрөн тэсвэрлэх чадавхыг бэхжүүлсэн Финландын урт хугацааны стратеги, стандарт, чанарт түшиглэсэн Сингапурын туршлага нь “hedging” стратеги ерөөсөө тогтсон жор бус харин тухайн улсын боломж, эрсдэл, дотоод чадамжид тохируулан тасралтгүй шинэчилж байх динамик процесс болохыг харуулж байна. Монгол Улсын хувьд богино хугацаандаа хамгаалалтын механизм бий болгох, дунд хугацаанд стандарт, эх үүсвэрийн төрөлжүүлэлт, институтийн чадавхыг бэхжүүлэх замаар “hedging” стратегийг хэрэгжүүлэх шаардлагатай юм.

Эцэст нь “hedging” бол стратегийн тодорхой бус байдлыг зориуд хадгалж, гадаад орчны эрсдэл, боломж хоёрыг зэрэг тооцсон прагматик хандлага бөгөөд олон улсын аюулгүй байдлын хуваагдмал орчинд жижиг улсуудад аюулгүй байдлаа хангах чиглэлд үлдэж буй цөөн боломжийн нэг юм. Харин амжилттай хэрэгжүүлэхэд стратегийн уян хатан байдал, үндэсний сөрөн тэсвэрлэх чадавх, салбар тус бүрийн нарийвчилсан эрсдэлийн үнэлгээг тооцсон бодлого, үйл ажиллагааны нарийн зохион зохицуулалт зайлшгүй шаардлагатай.

Эш татсан зохиогчдын тухай:

- Amitav Acharya нь Америкийн Вашингтоны их сургуулийн профессор, дэлхийн олон туйлт дэг журмыг (multiplex order) онолын түвшинд хөгжүүлсэн олон улсын харилцааны судлаач.
- Cheng-Chwee Kuik нь Малайзын Үндэсний их сургуулийн профессор бөгөөд hedging стратегийн онолыг системтэй боловсруулсан Зүүн Өмнөд Азийн судлаач.
- Da-Hoon Lim нь Өмнөд Солонгосын Ёонсэй их сургуулийн олон улсын харилцааны судлаач бөгөөд орчин үеийн аюулгүй байдлын орчин дахь hedging зан үйлийн динамикийг судалсан бүтээлээрээ танигдсан.
- Evelyn Goh нь Австралийн Үндэсний их сургуулийн профессор бөгөөд Зүүн Өмнөд Азийн аюулгүй байдлын стратеги, АНУ–БНХАУ-ын харилцаа, жижиг улсын гадаад бодлого судлаач.
- Peter J. Katzenstein нь Корнеллийн их сургуулийн профессор, олон улсын улс төрийн эдийн засаг ба соёлын аюулгүй байдлын онолд жинтэй хувь нэмэр оруулсан онолч.

Эх сурвалжийн жагсаалт

“Гадаад бодлогын үзэл баримтлал.” Монгол Улсын Их Хурал, 2011.

“Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал.” Улаанбаатар: Монгол Улсын Их Хурал, 2010.

Acharya, Amitav, and Peter J. Katzenstein. *The Making of Global International Relations: Origins and Evolution of IR at Its Centenary*. Cambridge: Cambridge University Press, 2023.

Al Jazeera, “China Tightens Export Controls on Rare-Earth Metals: Why This Matters.” October 10, 2025, <https://www.aljazeera.com/news/2025/10/10/china-tightens-export-controls-on-rare-earth-metals-why-this-matters>

Chatham House. “Trump’s Economic Rivalry with China Is Forcing Countries to Pick a Side.” *The World Today*, September 15–17, 2025.

Farrell, Henry, and Abraham L. Newman. “Weaponized Interdependence.” *International Security* 44, no. 1 (2019): 42–79.

Goh, Evelyn. *Meeting the China Challenge: The U.S. in Southeast Asian Regional Security Strategies*. Policy Studies 16. Washington, DC: East-West Center, 2005.

Kuik, Cheng-Chwee. “The Essence of Hedging: Malaysia and Singapore’s Response to a Rising China.” *Contemporary Southeast Asia* 30, no. 2 (2008): 159–185.

Lim, Da-Hoon. “Hedging in the Contemporary Security Environment.” *Asian Perspective* 41, no. 3 (2017): 387–406.

“The Hedging Strategy of Small States: Opportunities and Challenges of its Implementation in a Fragmented International Security Environment”

Altankhuu Badarch

Doctoral Candidate, Senior Expert, altankhuu@iss.gov.mn

The Institute for Strategic Studies, National Security Council, Ulaanbaatar, Mongolia

Abstract

In today's increasingly fragmented and polarized international security environment, hedging remains a vital—if increasingly constrained—strategy for small states seeking to preserve flexibility and safeguard national security. Mongolia's experience exemplifies the dual reality of hedging: its indispensability in navigating asymmetric dependencies, and its growing vulnerability to systemic polarization. This article argues that while the strategic space for hedging is narrowing, it continues to offer small states a pragmatic path to manage uncertainty, balance risks, and maintain limited autonomy. The paper seeks to contribute to broader debates on the adaptation of small states under conditions of geopolitical fragmentation by combining theoretical analysis with comparative case studies.

Keywords: Hedging strategy; Small States; Fragmented international security environment; Strategic autonomy

Received: November 5, 2025 | Accepted: December 23, 2025 | Published online: December 30, 2025



© The Author(s) 2025

<https://creativecommons.org/licenses/by/4.0/>.